



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар A/68

Арвайхээр

Зардлын хуваарь батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь, Аймгийн 2019 оны төсөв батлах тухай 09/10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.5 дахь заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаас Арвайхээр хотын ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажилд хуваарилсан зардлаас Арвайхээр хотын нийтийн эзэмшлийн талбайд мод, бут, сөөг тарих ажилд 100,000,000 (нэг зуун сая) төгрөг, олон наст таримал хуйлдаг зүлэг тарих ажилд 100,000,000 (нэг зуун сая) төгрөг, зүлэгжүүлэх талбайн хөрс боловсруулах, бэлтгэх ажилд 76,000,000 (далан зургаан сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Арвайхээр хотын ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль, тогтоомж батлагдсан төсвийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т хариуцуулсугай .

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100158